

БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК

2016.04.30

ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД  
ЗОРИУЛАВ

Лавлах утас 976-99111286



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016.02.29

Дугаар № 003

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ  
ДҮГНЭХ ТУХАЙ**

Бөөний Худалдаа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 02 сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.11 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:


**НЭГ.** Бөөний худалдаа ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны талаар гүйцэтгэх удирдлагын танилцуулсан тайланг хангалттай гэж үзсүгэй.

**ХОЁР.** Бөөний худалдаа ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан санхүүгийн тайланг үндэслэн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

**ГУРАВ.** Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг 2016 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Аудитын хороонд даалгасугай.

**ДӨРӨВ.** Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөсөн болон тогтоосон цаг хугацаанд үнэн зөвөөр тайлагнан, журмын дагуу НББ-д тусган ажиллахыг Бөөний худалдаа ХК-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

  
Б. ДӨЛБАДРАХ

ТТА4



ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016.02.29

Дугаар № 004

Улаанбаатар хот


**НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ**

Бөөний Худалдаа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 02 сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1; 46.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Бөөний худалдаа ХК-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтээр Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангаагүй байх тул 2016 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

**ХОЁР.** Тогтоолыг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.6 дахь заалтын дагуу 2016 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, тайлагнахыг Аудитын хороонд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА *Орвоолд* Б.ДӨЛБАДРАХ





ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016.02.29

Дугаар № 006

Улаанбаатар хот

**2016 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай**

Бөөний Худалдаа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 02 сарын 29-ний өдрийн ээлжит бус хуралдааны шийдвэр, Компанийн дүрмийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 59.4, 62 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. Бөөний худалдаа ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 4 сарын 30-ны өдрийн 13:00 цагт, Бөөний худалдаа ХК-ийн Баянгол дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Компанийн байранд зарлан хуралдуулсугай.

ХОЁР. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарласантай холбогдуулан хуралдааны зарыг түгээж, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Оюунгэрэлд даалгасугай.

ГУРАВ. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг олон нийтэд зарлан мэдээлэх өдрийг 2016 оны 03 сарын 10-ны өдөр байхаар тогтоосугай.

ДӨРӨВ. Хувьцаа эзэмшигчдийн бүргэлийн өдрийг 2016 оны 03 сарын 20-ны өдрөөр тасалбар болгосугай.

ТАВ. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов болон хуралдааны дэгийг тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.

ЗУРГАА. Хурал зохион байгуулах, болон тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Б.Дөлбадрах

Б.Илчбадрах

С.Оюунгэрэл

ДОЛОО. Хуралдаантай холбогдон гарах зардлыг Компаниас гаргахыг зөвшөөрсүгэй.


НАЙМ. Хувьцаа эзэмшигчдийг хурлаар хэлэлцэх асуудалтай танилцах нөхцлөөр хангах үүднээс 2016 оны 4 сарын 6-наас 4 сарын 7-ны өдрүүдэд мэдээлэл өгөх үйл ажиллагааг Компанийн байран дээр зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ЕС. Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны даргаар ТУЗ-ийн дарга Б.Дөлбадрахыг томилсугай.

АРАВ. Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны санал хураах хуудасны загварыг тогтоолын хавсралт №2-оор баталсугай.

АРВАН НЭГ. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид мэдэгдэхийг ТУЗНБД-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.ДӨЛБАДРАХ



**2016 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын тов болон хурлын дэг**

№	Хэлэлцэх асуудал	Хариуцан танилцуулах, гүйцэтгэх хүн	Шийдвэрийг төсөл	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх Ирцийг танилцуулах	ТУЗНБД		13:00-13:30
2	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон дэгийг танилцуулах	Хурлын дарга Б.Дөлбадрах		13:30-13:35
3	Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	Аудитын хороо	001	13:35-14:35
4	ТУЗ2016002 тоот тогтоолыг танилцуулах тайлбар хийх	Аудитын хороо		
5	ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ТУЗ-ийн дарга Б.Дөлбадрах	002	
6	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	Нэр дэвшүүлэх хороо	003	
7	Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай	Гүйцэтгэх удирдлага	004	
8	Санал хураалт			14:35-14:50
9	Тооллогын комиссын тогтоол танилцуулах		005	14:50-15:00
10	Хурлыг хаах			15:00-15:10

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
САНАЛ АВАХ ХУУДАС

1. Хувьцаа эзэмшигчийн овог \_\_\_\_\_
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр \_\_\_\_\_
3. Хувьцаа эзэмшигчийн нэр \_\_\_\_\_
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл \_\_\_\_\_
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар \_\_\_\_\_
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар \_\_\_\_\_
7. Санал өгөх хувьцааны тоо \_\_\_\_\_
8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр \_\_\_\_\_
9. Брокерын овог, нэр \_\_\_\_\_

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт/ 001 тоот тогтоолын төсөл/			
2	Ногдол ашгийн тухай тогтоолыг танилцуулах тайлбар хийх			
3	ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай / 002 тоот тогтоолын төсөл/			
4	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах, чөлөөлөх сонгох /003 тоот тогтоолын төсөл/			
5	Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай 004 тоот тогтоолын төсөл			

Хувьцаа эзэмшигчийн санал \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

**Санал авах хуудсын ашиглах санамж**

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаархи мэдээллийг 976-99155646, 976-99111286 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүйд болсон тухай тэмдэглэл (шалтгаан) \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Өдөр тутмын хэвлэлд өгөх зарын төсөл

## **БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Бөөний Худалдаа ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 04 дүгээр сарын 30-ны Бямба гарагийн 13:00 цагт Бөөний худалдаа ХК-ийн оффисын байранд зохион байгуулагдана.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Бөөний худалдаа ХК-ийн байрны 101 тоот

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2016.04.06

Хурлаар хэлэлцэх асуудлууд

- Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт
- Ногдол ашгийн тухай
- ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай
- ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах, чөлөөлөх, томилох тухай
- Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай төсөл эхлүүлэх тухай

Хурлын материал болон, шийдвэрийн төсөл холбогдох бусад баримттай 2016 орны 04 сарын 06-07-ны өдрүүдэд өөрийн байран дээр ирж танилцах бүрэн боломжтой.

Холбоо барих

Зохион байгуулах комиссын дарга: 99111286

ТУЗНБД 99155646



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4сарын 30 өдөр

Дугаар007

Улаанбаатар хот

**ТУЗ-ИЙН ДАРГА БОЛОН ДЭД ХОРООДЫН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ**

Бөөний худалдаа ХК-ийн 2016 оны 4 сарын 30-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын тэмдэглэл, Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйл, 78.1; 81 дүгээр зүйл, 81.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдсэн Б.Дөлбадрахыг улируулан сонгосныг баталсугай.

ХОЁР. Д.Дөлбадрахад Компанийн тухай хуульд заасан ТУЗ-ийн даргын эрх хэмжээг олгосугай.

ГУРАВ. ТУЗ-ийн дэргэд дараахи дэд хороодыг байгуулсугай.

- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Цалин урамшууллын хороо

ДӨРӨВ. Дэд хороодын гишүүдийг дараахи бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Аудитын хороо
  - Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Болоржаргал
  - Аудитын хорооны гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Батцэцэг
  - Аудитын хорооны гишүүн ТУЗ-ийн гишүүн Б.Илчбадрах
- Нэр дэвшүүлэх хороо
  - Нэр дэвшүүлэх хорооны дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Илчбадрах
  - Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, ТУЗ-ийн гишүүн Ж.Бадарч
  - Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ү.Нармандах
- Цалин урамшууллын хороо
  - Цалин урамшууллын хорооны дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Очбадрах
  - Цалин урамшууллын хорооны гишүүн, ТУЗ-ийн гишүүн Д.Мөнгөнцэцэг
  - Цалин урамшууллын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Болоржаргал

ТАВ. ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны гишүүдэд Компанийн хуульд заасан эрх хэмжээг олгож, Компанийн засаглалын кодексыг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ДӨЛБАДРАХ

